

**ЮНЕСКО-ИЙН МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ХӨГЖЛИЙН
ОЛОН УЛСЫН ХӨТӨЛБӨРИЙН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН
ХӨГЖЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮДЭД СУУРИЛСАН**

“МОНГОЛЫН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХӨГЖЛИЙН

ҮНЭЛГЭЭ” СУДАЛГААНЫ ЗӨВЛӨМЖ

Монголын хэвлэл мэдээллийн хөгжлийн үнэлгээг Улаанбаатар хотод 2013 оны 10 дугаар сарын 29-30-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Хэвлэл мэдээллийн үндэсний бага хуралд оролцогчидтой зөвлөлдсөний үндсэн дээр дараах зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

I. Үзэл бодолтой байх, түүнийгээ илэрхийлэх эрх чөлөө, хэвлэл мэдээллийн эрх чөлөөг баталгаажуулах

а/ Үндсэн хуулийн 16.16, 16.17 зүйлүүдийг Монгол Улсын нэгдэн орсон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19-р зүйлтэй нийцүүлэн нэмэлт өөрчлөлт оруулах.

б/ **Үзэл бодолтой байх, түүнийгээ илэрхийлэх эрх чөлөө, хэвлэл мэдээллийн эрх чөлөөг баталгаажуулах дараах хуулиудыг нэн даруй баталж, хэрэгжүүлэх**

- **Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хэвлэл мэдээллийн салбарын өвөрмөц онцлог, нийгэмд гүйцэтгэх үүрэгтэй нь уялдуулсан олон улсын эрх зүй, нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээг хөхиүлэн дэмжсэн хувилбараар нь дэмжин, батлах**
- **Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийг шинээр батлан гаргаж, хэрэгжүүлэх**

в/ Хэвлэл мэдээлэлтэй холбоотой харилцааг зохицуулж буй хууль тогтоомжийг олон улсын хэм хэмжээнд нийцүүлэн боловсронгуй болгох

- Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хуульд нийцүүлэн бусад холбогдох нууцын хуулиудыг өөрчлөх. Нууцын тухай бүх заалтад учирч болзошгүй хор хохирол болон нөхцлийг оруулбал зохино. Олон нийтийн мэдээлэлтэй байх зорилгоос учрах хор хохирол давамгайлбал мэдээлэл нээлттэй байхыг тодорхой заах
- Хувь хүний нууцыг хамгаалахтай холбогдсон бусад хуульд “мэдээллийг нууцлахыг зөвхөн тэр мэдээллийг задруулах нь тухайн хүний хууль ёсны ашиг сонирхолд ноцтой хохирол учруулах” болон “олон нийтийн мэдээлэлтэй байх эрх чөлөөнөөс тэр хохирол нь давамгайлсан нөхцөлд” л зөвшөөрөх тухай заалт оруулах, мэдээллийг задруулахыг хувь хүн зөвшөөрсөн бол нууц мэдээллийг ч нээлттэй болгохыг зөвшөөрөх.
- Олон нийтийн радио, телевизийн тухай, Иргэний хууль, Онц байдлын тухай, Зар сурталчилгааны тухай, Сонгуулийн бүх хуульд, Улсын бүртгэлийн тухай, Аж ахуйн тусгай зөвшөөрлийн тухай зэрэг холбогдох хуулиудад олон улсын эрх зүйд нийцүүлэн нэмэлт өөрчлөлт оруулах

- Контентид тавих хязгаарлалтыг дахин хянаж, садар самуун, шашны харгис үзэл зэрэг нэр томъёог хуулиар нарийн тодорхойлох, түрэмгийлэл, дайн болон гэмт хэргийг өдөөсөн агуулгатай нийтлэлийг хориглохдоо зөвхөн шууд өдөөн хатгасан хүрээгээр хязгаарлах.
- Олон улсын гэрээ, Монгол Улсын хууль тогтоомжинд нийцээгүй төрийн болон хуулиар эрх олгогдсон байгууллагын захиргааны шийдвэрийг хүчингүй болгох

II. Одоогийн төрийн зохицуулалтыг хүчингүй болгож, хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтыг хөхиүлэн дэмжих

- Монгол Улс гүтгэлэг, доромжлолыг эрүүгийн хуулиас хасч, сонгуулийн тухай бүх хуулиас гүтгэлэг доромжлолын заалтыг хүчингүй болгож, өөрийн зохицуулалтаар шийдвэрлэх механизмыг бүрдүүлэх
- Хуулиудад буй олон нийтэд мэдээлэх үүргийг хэвлэл мэдээлэлд үүрэг ногдуулсан заалтуудыг хүчингүй болгож, холбогдох төрийн байгууллагад нь тухайн үүргийг хүлээлгэх
- Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх мэргэжлийн эрхийг хязгаарласан хязгаарлалтыг хүчингүй болгох. Энэ асуудлыг эрүүгийн хуулиар биш мэргэжлийн байгууллагаар дамжуулан хэрэгжүүлэх ёстой.
- Интернэтийн одоогийн зохицуулалтыг эргэн харж, Засгийн газраас зохицуулах шийдвэрийг хүчингүй болгох

III. Хэвлэл мэдээллийн агуулгыг хөгжүүлэх бодлого гаргах, олон нийтийн нийтлэг эрх ашгийн дээдлэх талаар

а\ Хэвлэл мэдээллийн олон талт байдал, үндэсний түүх, хэл, соёл, ёс заншлыг хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн бүтээлийг дэмжих төрийн бодлого гаргах. Ингэхдээ хүйн болон орон нутгийн мэдээллийн хэрэгслийн онцлог, зах зээлийн нөхцөл байдлыг харгалзан үзэх

в\ Бүх нийтэд заавал үзүүлэх нэвтрүүлгийн бодлогыг ОЛОН НИЙТИЙН ЭРХ АШГИЙГ ДЭЭДЛЭН тодорхойлсны үндсэн дээр хиймэл дагуулаар дамжуулан орон даяар нэвтрүүлгээ цацах сувгийн эрх олгох. Ингэхдээ суваг сонгох нөхцөл шаардлагыг тодорхойлох, мэргэжлийн байгууллагуудын саналд үндэслэх, олон нийтэд ил тод мэдээлэх, орон нутгаас контент худалдан авах нөхцлийг харгалзан үзэх

IV. Хэвлэл мэдээллийн шударга өрсөлдөөн, салбарын хөгжлийг дэмжих зорилгоор ил тод байдлыг олон улсын нийтлэг хэм хэмжээний дагуу бий болгох, Үүнд:

б\ Хэвлэл мэдээллийн хэрэгслийн уншигч, үзэгч, сонсогчийн тоо, захиалгын тоо, зар сурталчилгааны орлого зэргийг ил тод мэдээлдэг болох

в\ Төрийн байгууллагуудын хэвлэл мэдээлэлтэй харилцах төсөв, гүйцэтгэлийг “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрх чөлөөний тухай” хуулийн дагуу олон нийтэд нээлттэй байх

жишгийг тогтоох. Нөгөө талаас хэвлэл мэдээллийн байгууллагууд үйл ажиллагааныхаа цар хүрээнээс үл хамааран төрийн байгууллагуудын мэдээлэл харилцааны тендэр, дуудлага худалдаанд ижил тэгш оролцох, хүртэх эрхтэй БАЙХ НӨХЦЛИЙГ БҮРДҮҮЛЭХ

д\ Төрийн байгууллагууд үйл ажиллагааныхаа талаар мэдээлэл өгөхдөө өөрийн хэвлэлийн алба, мэдээллийн технологийн алба гэх мэт бүтэц бий болгон хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа явуулах, хэвлэл мэдээллийн ажилтнуудад нэг эшт эх сурвалжийн өрөөсгөл, тэнцвэргүй мэдээлэл өгөх зэргээр “Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль”-ийг зөрчиж байгаа үйлдлийг зогсоох

е\ Үндэсний давтамжийн зурвасын төлөвлөлт, түүний хэрэгжилт, ялангуяа тоон өргөн нэвтрүүлгийн зурвасын хуваарилалтыг ил тод болгох, шийдвэр гаргах үйл явцад олон нийтийн оролцоог хангах, хүйн хэвлэл мэдээлэлд радио давтамжийн нөөц төлөвлөх

V. Сэтгүүл зүйн мэргэжлийн стандарт тогтоож, чанарыг сайжруулах

- Сэтгүүл зүйн мэргэжлийн хэм хэмжээг тогтоож, чанар чансааг нэмэгдүүлэхийн төлөө төрийн болон төрийн бус сэтгүүл зүйн байгууллагууд хамтран ажиллах
- Төрийн болон хувийн сэтгүүл зүйн их, дээд сургуулиудын хоорондын хамтын ажиллагааг сайжруулах, сэтгүүлч бэлтгэдэг их дээд, сургууль дундын сэтгүүлзүйн боловсролын МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛ БАЙГУУЛАХ
- Мэргэжлийн байгууллагуудын чадавхийг дээшлүүлэх, нэр хүндийг өргөхийн тулд нөлөөллийн ажил явуулах
- Их дээд сургуулиуд сэтгүүлч мэргэжлээр элсүүлэх журам, болзлын шалгуурыг боловсронгуй болгон батлуулж, хэрэгжүүлэх
- ИНБ-ууд мэргэжлийн байгууллагуудтай хамтарч системтэй мониторинг хийн иргэдэд мэдээлэлтэй байх, нийгэмд дуу хоолойгоо хүргэх гүүр болж ажиллах

VI. Мэргэжлийн сургалт, судалгаа

- Сэтгүүл зүйн боловсролын стандарт, хөтөлбөрийн агуулгыг шинэчлэн боловсронгуй болгох, олон хөтөлбөр өрсөлдөх боломжийг хангах замаар сургалтыг чанаржуулах
- Хэвлэл мэдээллийн дунд түвшний менежерүүд болон санхүүгийн менежерүүдэд системчилсэн сургалт зохион явуулах
- Мэргэжлийн академик сургалтын эрэлт хэрэгцээний болон үнэлгээний цогц судалгаа хийх, мэргэжилтнийг сэтгүүл зүйн зах зээлээ мэдэрч хэрэгцээ шаардлагад нийцүүлэн бэлтгэх, мэргэшүүлэх
- Шинэ дэвшилтэд техник технологийн системчилсэн сургалт зохион байгуулах

VII. Хөдөлмөрийн харилцааг зохицуулах, байгууллагыг чадавхижуулах

- Хэвлэл мэдээллийн байгууллагын дэргэдэх үйлдвэрчний эвлэлийн хороодыг түшиглэн Салбарын үйлдвэрчний эвлэлийн холбоо байгуулах
- Хэвлэл мэдээллийн салбарын хөдөлмөрийн харилцааны хэм хэмжээ тогтоох
- ҮЭ-ийн байгууллагын талаар ажилтан, удирдлагад сургалт, сурталчилгаа хийх
- Хөдөлмөрлөх эрх ашгаа хамгаалах талаар редакци болон эздийг хамруулсан сургалт зохион байгуулах